

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Увс-Авто зам засвар, арчлалт” ТӨХК-ийн 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: УВА-2024/27/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2024 он	Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Ахлах аудитор: Ч.Мөнхтогтох Утас: 70453721, Цахим хаяг: Munktogtokhch@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

“УВС–АВТО ЗАМ ЗАСВАР,
АРЧЛАЛТ” ТӨРИЙН ӨМЧИТ
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Р.ТӨМӨРЧӨДӨР ТАНАА

2024.03.15 № УВА-2024/27/НА-СТА-ТӨА
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Увс-Авто зам засвар, арчлалт” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

“Увс-Авто зам засвар, арчлалт” ТӨХК-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

“Увс-Авто зам засвар, арчлалт” ТӨХК-нь 45,000.0 мянган төгрөгийн зээл авч, зээлийн хүүд 1,125.0 мянган төгрөгийг төлсөн байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

0200200836

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	500,178,950.16	463,573,512.57
1.1.2	Дансны авлага	100,653,210.10	37,368,874.99
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	0	0.01
1.1.4	Бусад авлага	830,000	0.00
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	125,316,106.2	344,620,150.80
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	726,978,266.45	845,562,538.37
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	616,859,089.31	608,152,960.87
1.2.2	Биет бус хөрөнгө	96,120,000.00	96,120,000
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	712,979,089.31	704,272,960.87
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,439,957,355.76	1,549,835,499.24
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	526,999.94	40,086,071.95
2.1.1.2	Цалингийн өглөг	0.00	0.00
2.1.1.3	Татварын өр	55,252,693.14	122,830,751.66
2.1.1.4	НДШ – ийн өглөг	261,502.03	2,894,545.27
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	56,041,195.11	165,811,368.89
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	430,651,551.00	430,651,551.00
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	430,651,551.00	430,651,551.00
2.2	Өр төлбөрийн нийт дүн	486,692,746.11	596,462,919.89
2.3	Эздийн өмч	177,307,484.23	177,307,484.23
2.3.1	Өмч:- төрийн	177,307,484.23	177,307,484.23
2.3.2	хувийн		
2.3.3	хувьцаат		
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	182,793,596.27	182,793,596.27
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	166,445,068.62	166,445,068.62
2.3.9	Хуримтлагдсан ашиг	426,718,460.53	426,826,430.23
2.3.11	Эздийн өмчийн дүн	953,264,609.65	953,372,579.35
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	1,439,957,355.76	1,549,835,499.24

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,976,696,176.92	2,038,467,149.64
2	Борлуулалтын өртөг	1,876,253,865.00	1,731,043,525.83
3	Нийт ашиг(алдагдал)	100,442,311.92	307,423,623.81
4	Түрээсийн орлого		
5	Хүүгийн орлого		
6	Ногдол ашгийн орлого		
7	Эрхийн шимтгэлийн орлого		
8	Бусад орлого	35,000.00	3,980,000
9	Борлуулалт, маркетингийн зардал	190,724,659.28	245,501,785.76
10	Ерөнхий ба удирдлагын зардал	71,560,598.63	61,886,396.90
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал	1,769,895.69	3,907,471.45
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)		
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(163,577,841.68)	107,969.70
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(163,577,841.68)	107,969.70
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(163,577,841.68)	107,969.70
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(163,577,841.68)	107,969.70
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл	177,307,484.23	182,793,596.27	166,445,068.62	590,296,302.21	1,116,842,451.33
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			0	(163,577,841.68)	(163,577,841.68)
Өмчид гарсан өөрчлөлт					
Зарласан ногдол ашиг					
2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	177,307,484.23	182,793,596.27	166,445,068.62	426,718,460.53	953,264,609.65
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				107,969.70	107,969.70
Зарласан ногдол ашиг					
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	177,307,484.23	182,793,596.27	166,445,068.62	426,826,430.23	953,372,579.35

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	2,192,353,407.00	2,295,564,430.50
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,192,353,407.00	2,295,564,430.50
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,192,353,407.00	2,292,184,430.50
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
	Буцаан авсан албан татвар		
	Татаас, санхүүжилтийн орлого		
	Бусад мөнгөн орлого	800,000.00	3,380,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,172,998,011.06	2,332,444,868.09
	Ажиллагчдад төлсөн	497,856,821.40	535,977,695.33
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	163,091,725.79	121,542,148.54
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,361,617,594.17	1,517,601,600.95
	Ашиглалтын зардалд төлсөн	6,700.00	542,944.98
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн		
	Хүүгийн төлбөрт төлсөн		
	Татварын байгууллагад төлсөн	108,835,670.50	107,667,030.41
	Даатгалын төлбөрт төлсөн		
	Бусад мөнгөн зарлага	41,589,499.00	49,113,447.88
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	19,355,395.94	(36,880,437.59)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
	Хүлээн авсан хүүгийн орлого		
	Хүлээн авсан ногдол ашиг		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
	Төрөл бүрийн хандив		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		

	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
	Төлсөн ногдол ашиг		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	19,355,395.94	(36,880,437.59)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	480,823,554.22	500,178,950.16
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	500,178,950.16	463,573,512.57

2.5 Аудит хийсэн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	2023 он		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Бүтээгдэхүүн үйлдвэрлэл	2,203,300.00	2,038,467.15	(164,832.85)	92.52
	Үүнээс: Улсын чанартай зам засвар арчлалтын ажил	2,103,300.00	2,038,467.15	(64,832.85)	96.92
2	Орон нутгийн чанартай зам засвар арчлалтын ажил	100,000.00	-	(100,000.00)	0.00
	Нийт орлого	2,203,300.00	2,042,447.15	(160,852.85)	92.70
	Бусад орлого	-	3,980.00	3,980.00	
3	Нийт зардал	2,137,201.00	2,042,339.18	(94,861.82)	95.56
3.1	Үүнээс: Удирдлагын зардалд	266,620.80	311,295.65	44,674.85	116.76
4	Татварын өмнөх ашиг	66,099.00	107.97	(65,991.03)	0.16
5	Цэвэр ашиг /алдагдал/	59,489.10	97.17	(59,391.93)	0.16
6	Төсвийн төлбөр	296,302.90	468,858.55	172,555.65	158.24
6.1	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар	4,597.00	-	(4,597.00)	0.00
6.2	Нэмэгдсэн өртгийн албан татвар	168,824.00	201,974.40	33,150.40	119.64
6.3	Түгээмэл тархацтай ашигт малтмал	-	-	-	0.00
6.4	Ус ашигласны төлбөр	17.00	133.64	116.64	786.12
6.5	Газрын татвар	961.20	9,863.90	8,902.70	1026.21
6.6	Галт зэвсгийн албан татвар	-	-	-	0.00
6.7	Агаарын бохирдлын төлбөр	148.00	160.60	12.60	108.51
6.8	Тээврийн хэрэгслийн татвар	1,718.00	1,135.80	(582.20)	66.11
6.9	Гадаадын ажиллах хүч ажиллуулсны татвар	-	-	-	0.00
6.1	Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэл	171,831.00	184,738.74	12,907.74	107.51
6.11	Үл хөдлөх хөрөнгийн татвар	2,578.00	1,681.89	(896.11)	65.24
6.12	ХХОАТ	53,697.00	60,266.90	6,569.90	112.24
6.13	АТӨЯХ-ийн албан татвар	-	-	-	0.00
6.14	Газрын татвар	8,591.50	8,902.70	311.20	103.62
7	Төрийн өмчийн ногдол ашиг	29,744.60	-	(29,744.60)	0.00

8	Ажиллагсдын тоо	49.00	49.00	-	100.00
9	Нийт цалингийн сан	624,597.00	719,711.57	95,114.57	115.23
10	Нэг ажилтны сарын дундаж цалин	1,062.20	1,223.99	161.79	115.23
11	Борлуулалтын орлогын 1 төгрөгт ногдох зардал	0.97	0.99	0.02	102.06
12	Хөрөнгө оруулалт	104,890.40	99,305.00	(5,585.40)	94.68
13	Нийт авлага	21,200.20	37,368.87	16,168.67	176.27
14	Нийт өглөг	483,211.50	596,462.92	113,251.42	123.44
14.1	Үүнээс: богино хугацаат өр төлбөрт	-	165,811.37	165,811.37	0.00
14.2	Урт хугацаат өр төлбөрт	430,651.55	430,651.55	-	100.00

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 145,978.9 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 1,125.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 144,853.9 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

5.1 Албан шаардлага

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтад “Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулна”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 3.2 дахь хэсэгт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга бат, хэмнэлтийн горимыг мөрдүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэхтэй холбогдсон харилцаанд энэ хуулийг мөрдөх ба бусад хуульд өөрөөр заасан бол энэ хуульд заасныг дагаж мөрдөнө”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.16 дахь хэсэгт “Төрийн өмчит, төрийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр зээл авч, үнэт цаас гаргана”, 21.20 дахь хэсэгт “Энэ зүйлийн 16-д заасан зөвшөөрөлгүйгээр төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээд нь зээл авах, үнэт цаас гаргахыг хориглоно” гэж заасныг зөрчин “УВС АЗЗА” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Р.Төмөрчөдөр 2023 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 01 дугаартай зээлийн гэрээг иргэн С.Юнгэртэй байгуулж 45,000.0 мянган төгрөгийн үндсэн зээл авч, зээлийн хүүд 1,125.0 мянган төгрөгийг төлсөн зөрчил илэрсэн тул албан шаардлага өглөө.

5.2 Зөвлөмж

Илрүүлэлт:

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалын 5 дугаар хавсралтаар баталсан “Автомашин сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм”-ын 5.1 дахь дахь хэсэгт “Аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь автомашины резин дугуйн эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн нормыг үйлдвэрлэгчийн тогтоосон эдэлгээний нөөцийн доод хязгаарыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө” 5.2 дахь хэсэгт “Аж ахуй нэгж, байгууллага, иргэд нь автомашины зай хураагуур буюу аккумуляторын эдэлгээний хугацааны нөөцийн доод хязгаарын нормыг үйлдвэрлэгчийн тогтоосон эдэлгээний нөөцийн доод хязгаарыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө” 5.5 дахь хэсэгт “Автомашин үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний доод хязгаар”, 5.5-ын тайлбар хэсэгт “Автомашин үндсэн агрегат, зангилаануудын эдэлгээний нөөцийн доод хязгаарын нормыг тухайн эд ангийг үйлдвэрлэсэн үйлдвэрлэгчийн тогтоосон эдэлгээний нөөцийг үндэс болгон аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө тогтоож мөрдөнө”, “Тухайн эд ангид тогтоосон эдэлгээний нөөц тодорхой бус үед хүснэгт 5.5-д заасан эдэлгээний нөөцийг баримжаа болгон аж ахуйн нэгж байгууллага өөрсдөө тогтоож мөрдөж болно” гэж заасан байхад үндсэн агрегат, зангилаануудын эд ангийн доод хязгаарын нормыг тооцохгүйгээр

оны 390 дүгээр тушаалыг мөрдөөгүй									
Дүн									
Нийт дүн								1	144.8

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ	1	1			1			